



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г.корпус, 5 даяар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: uba@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025. 04. 25 № 01/233
талай _____-ны № _____-т

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН
СТАНДАРТЫН ГАЗРЫН ДАРГА
Г.БАЯРСАЙХАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хот байгуулалт, хотын стандартын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд бүтцийн өөрчлөлт хийгдэж "Нийслэлийн дагуул хот, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн газар" болон "Нийслэлийн Хотын стандартын газар"-аас 203.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Аудитын гол асуудал

Төсвийн шууд захирагч нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гэрээ болон гүйцэтгэлийн тайланг tender.gov.mn болон шилэн дансны системд ил тодоор мэдээлэл байршуулаагүй, тайлант оны худалдан авалтын захиалга хүсэлт өгөөгүй цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.

Бусад асуудал

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тайлант онд 4 зорилтын хүрээнд 55 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, 97.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

1425010019

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

 М.ЭРДЭНЭЖАРГАЛ